

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2023/35/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төвөөр: Улаанбаатар, Нурхун сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7711-4411 / 7711-4209

2023.02.15 № 169

тантай _____ -ны № _____ -т

Г ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Э.ЖАВХЛАН ТАНАА

Г Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн оорчлолт, мөнгөн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хиихдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бараа материалын тайланд орлого, зарлагын нэр төрлийг бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, 2022 онд байгуулсан худалдан авах гэрээүүдэд бараа, бүтээгдэхүүний худалдан авалтын нөхцөл, шаардлагыг нарийвчлан тусгаагүй байна. Мөн хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа явуулах тусгай зөвшөөрөлгүй, бүтээгдэхүүн худалдан борлуулдаг объект тодорхойгүй аж ахуй нэгжээс худалдан авалт хийсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, ... этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020050

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДЬОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,312,399.42	75,045,583.53
31	МОНГОН ХОРОНГО	00.00	00.00
33	АВЛАГА	88,328.16	12,939,186.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	88,328.16	00.00
335	Бусад авлага	00.00	12,939,186.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	12,939,186.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,224,071.26	62,106,397.53
354	Хангамжийн материал	18,224,071.26	62,106,397.53
35410	Бичиг хэргийн материал	1,166,000.00	1,166,000.00
35420	Аж ахуйн материал	17,058,071.26	60,940,397.53
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	460,354,688.75	469,303,021.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	460,354,688.75	469,303,021.51
392	Биет хөрөнгө	400,669,688.75	409,618,021.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	346,326,587.80	375,771,475.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,881,390.64	-29,656,520.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,500,000.00	18,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,166,666.56	-9,249,999.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,420,000.00	27,420,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,433,999.92	-9,786,999.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,204,891.26	54,204,891.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,299,733.19	-21,959,824.79
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-625,000.08
393	Биет бус хөрөнгө	59,685,000.00	59,685,000.00
39301	Програм хангамж	9,600,000.00	9,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-9,600,000.00	-9,600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	59,685,000.00	59,685,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	478,667,088.17	544,348,605.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХОРОНГО ӨМЧИЙН ДҮН	478,667,088.17	544,348,605.04
51	Засгийн газрын хувь оролцоо	478,667,088.17	544,348,605.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	259,801,915.41	259,801,915.41
51101	Өмч: - төрийн	259,801,915.41	259,801,915.41
512	Хуримтлагдсан үр дүн	118,555,829.92	184,237,346.79
51210	Өмнөх үеийн үр дүн	118,555,829.92	118,555,829.92
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	65,681,516.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,309,342.84	100,309,342.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	478,667,088.17	544,348,605.04

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	422,227,563.26	672,147,831.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,040,971.26	65,305,724.27
120	Нийтлэг татварын бус орлого	8,040,971.26	65,305,724.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,040,971.26	65,305,724.27
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,040,971.26	65,305,724.27
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	77,773,392.00	606,842,107.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	447,678,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	447,678,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,796,100.00	00.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	14,617,100.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,773,392.00	159,163,207.00
131103	ЗГНХ, ЗДНХ өрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,218,000.00	61,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,555,392.00	98,063,207.00

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	447,290,841.23	606,466,314.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	447,290,841.23	606,466,314.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430,658,141.23	606,466,314.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	197,422,954.48	224,606,349.23
210101	Үндсэн цалин	184,577,198.48	183,198,625.10
210102	Нэмэгдэл	12,845,756.00	33,859,580.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	6,853,500.00
210104	Урамшуулал	00.00	694,644.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,744,004.00	27,352,871.56
210201	Тэтгэврийн даатгал	18,791,507.12	18,744,259.74
210202	Тэтгэмжийн даатгал	1,960,199.22	2,336,294.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,618,199.36	1,672,618.13
210204	Ажилгүйдлийн даатгал	397,499.86	418,154.60
210205	Эрүүл мэндийн даатгал	3,976,598.44	4,181,544.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,915,048.64	16,357,200.00
210301	Гэрэл, цахилгаан	7,108,585.72	9,144,200.00
210302	Түлш, халаалт	2,969,772.92	5,398,415.00
210303	Цэвэр, бохир ус	836,690.00	1,814,585.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,999,535.20	1,873,200.00
210401	Бичиг хэрэг	4,993,210.00	780,400.00
210402	Тээвэр, шатахуун	6,012,408.00	640,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,917.20	452,300.00
2105	Нормативт зардал	1,332,700.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,332,700.00	00.00
210502	Хоол, хунс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	334,000.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	334,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	330,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,860,274.00	283,523,494.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,530,520.00	281,869,719.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,780.00	154,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	739,500.00	847,200.00
210807	Газрын төлбөр	292,224.00	548,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	177,250.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,049,624.91	52,423,199.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	46,493,969.78	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,598,952.45	20,496,555.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,632,700.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,632,700.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,632,700.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-25,063,277.97	65,681,516.87
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,900,436.91	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,900,436.91	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,900,436.91	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-27,963,714.88	65,681,516.87

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	414,186,592.00	606,842,107.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	414,186,592.00	606,842,107.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	447,678,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	447,678,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,796,100.00	00.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	14,617,100.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,773,392.00	159,163,207.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,218,000.00	61,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,555,392.00	98,063,207.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	414,186,592.00	606,842,107.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	414,186,592.00	606,842,107.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,553,892.00	606,842,107.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	197,422,954.48	222,187,331.09
210101	Үндсэн цалин	184,577,198.48	180,962,129.09
210102	Нэмэгдэл	12,845,756.00	33,677,058.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	6,853,500.00
210104	Урамшуулал	00.00	694,644.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,744,004.00	29,683,561.54
210201	Тэтгэврийн даатгал	18,791,507.12	20,527,383.33
210202	Тэтгэмжийн даатгал	1,960,199.22	2,336,294.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,618,199.36	1,818,635.82
210204	Ажилгүйдлийн даатгал	397,499.86	454,659.04
210205	Эрүүд мэндийн даатгал	3,976,598.44	4,546,588.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,915,048.64	16,357,200.00
210301	Гэрэл, цахилгаан	7,108,585.72	9,144,200.00
210302	Түлш, халаалт	2,969,772.92	5,473,900.00
210303	Цэвэр, бохир ус	836,690.00	1,739,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,145,635.20	1,873,200.00
210401	Бичиг хэрэг	5,549,310.00	780,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,602,408.00	640,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,917.20	452,300.00
2105	Нормативт зардал	1,286,050.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,286,050.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	334,000.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	334,000.00	00.00
2107	Томилголт, зочны зардал	00.00	330,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,711,111.00	304,484,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,558,607.00	302,830,395.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,780.00	154,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	22,000.00
210806	Мэдрэлэл, технологийн үйлчилгээ	739,500.00	847,200.00
210807	Газрын төлбөр	292,224.00	548,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,995,088.68	31,926,644.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,038,386.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,632,700.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,632,700.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,632,700.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний ноц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	167,153,658.08	527,264,916.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	167,153,658.08	527,264,916.33
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-29,604,541.44	-29,604,541.44
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	118,555,829.92	478,667,088.17
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	118,555,829.92	478,667,088.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	118,555,829.92	478,667,088.17
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын мөрвүүдэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	65,681,516.87	65,681,516.87
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	184,237,346.79	544,348,605.04

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	447,678,900.00	415,752,255.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	447,678,900.00	415,752,255.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	447,678,900.00	415,752,255.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,986,400.00	222,187,331.09
210101	Үндсэн цалин	185,549,700.00	180,962,129.09
210102	Нэмэгдэл	49,464,700.00	33,677,058.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,972,000.00	6,853,500.00
210104	Урамшуулал	00.00	694,644.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,373,200.00	29,683,561.54
210201	Тэтгэврийн даатгал	21,576,000.00	20,527,383.33
210202	Тэтгэмжийн даатгал	2,449,300.00	2,336,294.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,959,400.00	1,818,635.82
210204	Ажилгүйдлийн даатгал	489,900.00	454,659.04
210205	Эрүүл мэндийн даатгал	4,898,600.00	4,546,588.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,357,200.00	10,357,200.00
210301	Гэрэл, цахилгаан	3,144,200.00	3,144,200.00
210302	Түлш, халаалт	5,291,600.00	5,473,900.00
210303	Цэвэр, бохир ус	717,400.00	1,739,100.00
210304	Байрны түрээс	1,204,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,873,200.00	1,873,200.00
210401	Бичиг хэрэг	675,400.00	780,400.00
210402	Тээвэр, шатахуун	460,100.00	640,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	737,700.00	452,300.00
2107	Томилолт, зочны зардал	504,300.00	330,000.00
210702	Дотоод албан томилолт	504,300.00	330,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	152,584,600.00	151,320,963.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,419,700.00	149,667,188.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,500.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,200.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	154,000.00	154,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	56,100.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	963,200.00	847,200.00
210807	Газрын төлбөр	548,900.00	548,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	447,678,900.00	447,678,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	447,678,900.00	447,678,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	447,678,900.00	447,678,900.00

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,773,392.00	159,163,207.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,773,392.00	159,163,207.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,773,392.00	159,163,207.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	379,753.11	6,000,000.00
210301	Гэрэл цахилгаан	225,753.10	6,000,000.00
210302	Түлш, халаалт	154,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,410,158.00	00.00
210401	Бичиг хэрэг	3,707,100.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	4,635,408.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	67,650.00	00.00
2105	Нормативт зардал	1,286,050.00	00.00
210501	Эм, бөлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,286,050.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,974,976.00	153,163,207.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,974,976.00	153,163,207.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,284,250.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,284,250.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	438,204.89	00.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	438,204.89	00.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	438,204.89	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,773,392.00	159,163,207.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,773,392.00	159,163,207.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,510,000.00	61,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,555,392.00	98,063,207.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 13.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд: Ажил үйлчилгээний урьдчилгаа төлбөрт шилжүүлсэн 10.8 сая төгрөгийг, хөрөнгө худалдан авахаар шилжүүлсэн 2.1 сая төгрөгийг тус тус авлагаар, 5.0 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгөнд 625.0 мянган төгрөгийн элэгдлийг тооцуулан бүртгэл, тайланд тусгуулсан.

Аудитаар нийт 18.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 5.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 12.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Өдөр өнжүүлэх хүүхэд харах төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах арга хэмжээнд анхан шатны баримтгүй 0.2 сая төгрөгийг илүү зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

2. Тушаалын дагуу ажилтнаас суутган авсан сахилгын шийтгэлийн 0.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, сахилгын шийтгэлтэй ажилтанд 0.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.
3. Сэтгэшгүй-Энерги ХХК-аас 4.9 сая төгрөгийн хүнс, бичиг хэргийн бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг хийн нярвын тайланд орлого, зарлагын нэр төрлийг хүнсний багц гэж бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, худалдан авалт хийсэн бүтээгдэхүүний нэр төрөл тодорхойгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 онд байгуулсан худалдан авах гэрээүүдэд бараа, бүтээгдэхүүний худалдан авалтын нөхцөл, шаардлагыг нарийвчлан тусгаагүй байна. Мөн хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа явуулах тусгай зөвшөөрөлгүй, бүтээгдэхүүн худалдан борлуулдаг объект тодорхойгүй Эрхэм өсөх ундарга ХХК-аас 12.4 сая төгрөгийн хүнс, бичиг хэргийн бараа бүтээгдэхүүний худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, ... этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

/Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Урьдчилгаа төлбөрт шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг авлагаар бүртгээгүй.	1	10,850.0	1	10,850.0	-	-	1	10,850.0	-	-	-	-
Тавилга, эд хогшил худалдан авсан боловч бодитоор хөрөнгө ирээгүй	1	2,089.1	-	-	1	2,089.1	1	2,089.1	-	-	-	-
Элэгдэл тооцроогүй	1	625.0	1	625.0			1	625.0	-	-	-	-
Дүн	3	13,564.2	2	11,475.0	1	2,089.1	3	13,564.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бодит гүйцэтгэлээр зарцуулалтыг тайлагнаагүй.	1	236.9	1	236.9	-	-	-	-	-	-	-	-
Сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгосон, цалингаас суутгасан сахилгын шийтгэлийг төсөвт төвлөрүүлээгүй	1	687.2	1	687.2	-	-	-	-	-	-	-	-
Анхан шатны баримтын бүрдэлгүй худалдан авалт хийсэн	1	4,950.0	1	4,950.0	-	-	-	-	-	-	-	-
Хүнсний үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүн худалдан борлуулдаг объект тодорхойгүй ААН-ээс худалдан авалт хийсэн	1	12,364.7	-	-	1	12,364.7	-	-	-	-	-	-
Дүн	4	18,238.	3	5,874.1	1	12,364.7	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 ширхэг зарлагын мөнгөн гүйлгээг байршуулаагүй байна.	1	22,413.1	-	-	-	-	1	22,413.1
Дүн	1	22,413.1	-	-	-	-	1	22,413.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хүнсний үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүн худалдан борлуулдаг объект тодорхойгүй ААН-ээс худалдан авалт хийсэн	1	12,364.7	-	-	1	12,364.7	-	-
Дүн	1	12,364.7	-	-	1	12,364.7	-	-
Нийт дүн	2	34,777.8	-	-	1	12,364.7	1	22,413.1

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-